



Foto: hudební skupina Gerege, autor: Nikolaj Tretjančenko

Vítáme Vás, Чех – Монголын найрамдал

u nového formátu pravidelného informování o dění ve Společnosti česko-mongolského přátelství a spolupráce. Naše organizace funguje již více než jeden rok a za tu dobu se nám podařilo vybudovat stabilní základ i smysluplné aktivity. Přesto si uvědomujeme, že jsme se zatím nedostali do povědomí celé mongolské komunity ani všech lidí, které témata česko-mongolské spolupráce zajímají. Právě tento newsletter by k tomu měl pomoci.

Co v něm najdete? Především důležité odkazy, kontakty a praktické informace, které vám mohou být užitečné jak v pracovním, tak i v běžném životě v České republice. Zároveň se s vámi budeme pravidelně dělit o zajímavosti a novinky z uplynulého měsíce – o to, co se v naší společnosti odehrálo, na čem jsme se podíleli nebo co jsme pomohli iniciovat. Samozřejmě budou také pozvánky a upoutávky na plánované akce.

Každé číslo newsletteru bude mít i své **hlavní téma**. V tomto vydání se chceme věnovat možnosti bezplatného testování a případné léčby hepatitidy D pro mongolské spoluobčany žijící v České republice.

Budeme velmi rádi, pokud se na podobě newsletteru budete podílet i vy. Máte-li námět, nápad nebo informaci, o kterou byste se chtěli s ostatními čtenáři podělit, neváhejte nás kontaktovat. Vaše příspěvky u nás budou vítány.

Přejeme vám příjemné a inspirativní čtení.

Jana Uher

хамтын ажиллагааны нийгэмлэгийн үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл хүргэх энэхүү шинэ хэлбэрт та бүхнийг тавтай морилно уу. Манай байгууллага нэг жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ хугацаанд бид тогтвортой суурь, утга учиртай олон үйл ажиллагааг хэрэгжүүлж чадсан. Гэсэн хэдий ч Чех–Монголын хамтын ажиллагааны сэдвийг сонирхдог бүх хүн, мөн Чех Улсад амьдарч буй монголчуудын өргөн хүрээнд бидний үйл ажиллагаа хараахан бүрэн танигдаж амжаагүй байгааг бид ухамсарлаж байна. Энэхүү мэдээллийн товхимол (newsletter) нь үүнд хувь нэмэр оруулах зорилготой юм.

Эндээс та юу олж унших вэ? Юуны өмнө Чех Улсад ажиллаж, амьдарч буй танд хэрэг болохуйц чухал холбоосууд, холбоо барих мэдээлэл болон практик зөвлөмжүүдийг хүргэнэ. Мөн өнгөрсөн сард манай нийгэмлэгийн хүрээнд болсон онцлох үйл явдал, мэдээ мэдээллийг та бүхэнтэй тогтмол хуваалцах болно. Түүнчлэн удахгүй зохион байгуулагдах арга хэмжээний талаарх урилга, танилцуулгууд багтана.

Мэдээллийн товхимлын дугаар бүр өөрийн гэсэн гол сэдэвтэй байх бөгөөд энэ удаагийн дугаарт Чех Улсад амьдарч буй монгол иргэдэд зориулсан D төрлийн гепатитын үнэ төлбөргүй шинжилгээ, шаардлагатай тохиолдолд эмчилгээ хийлгэх боломжийн талаар онцлон хүргэж байна.

Та бүхнийг энэхүү мэдээллийн товхимлыг хамтран бүтээхэд урьж байна. Хэрэв танд хуваалцахыг хүссэн санал, санаачилга эсвэл хэрэгтэй мэдээлэл байвал бидэнтэй холбогдоорой. Таны оруулсан хувь нэмэр бидэнд үргэлж нээлттэй, таатай байх болно.

Танд таатай, урам зориг өгөхүйц уншлага хүсье.



OBSAH/АГУУЛГА

MongolSpace.com

Katalog
Mongolských
podnikatelů
**Монгол бизнес
эрхлэгчдийн
каталог**

Hepatitis D
**D төрлийн
гепатит**

Náš web v
mongolštině
**Монгол хэл
дээрх вэб сайт**

Oznámení
мэдэгдэл

Důležitá
informace
**Чухал
мэдээлэл**

www.mongol.space.com

MongolSpace.com je virtuální muzeum věnované Mongolsku, jehož základem je mongolská část sbírky Malého asijského muzea manželů Šimových. Pokud tento web ještě neznáte, určitě vám doporučujeme se na něj podívat. A prozkoumat i virtuální prohlídku jurtou.

Zároveň vyzýváme všechny, kteří vlastní zajímavé artefakty, předměty či materiály s vazbou na Mongolsko a chtěli by je zdokumentovat a stát se součástí tohoto virtuálního muzea, aby nás neváhal kontaktovat.

MongolSpace.com нь Монгол Улсад зориулсан виртуал музей бөгөөд уг төслийн үндэс нь Шимагийн гэр бүлийн Мал Ази тивийн музейн сан хөмрөгт багтдаг Монголын хэсэг юм. Хэрэв та энэ вэб сайтыг харахан мэдэхгүй бол заавал зочлон үзэхийг зөвлөж байна. Мөн гэр (юрта)-ээр хийсэн виртуал аяллыг сонирхоорой.

Үүний зэрэгцээ Монгол Улстай холбоотой сонирхолтой эд өлгийн зүйлс, хэрэглэгдэхүүн эсвэл материал эзэмшдэг бөгөөд тэдгээрийг баримтжуулж, энэхүү виртуал музейн нэг хэсэг болгохыг хүсэж буй хүн бүрийг бидэнтэй холбогдохыг уриалж байна.

Výzva pro podnikatele - Бизнес эрхлэгчдэд зориулсан уриалга

Jste podnikatelka nebo podnikatel a vaše práce má vazbu na Mongolsko?

Je jedno, jestli jste kadeřnice, trenérka, prodáváte kašmírové svetry, dovážíte mongolské výrobky, nebo provozujete restauraci s mongolskými specialitami.

Připravujeme otevřenou online platformu, která bude přehledným a důvěryhodným místem pro všechny, kdo propojují Česko a Mongolsko prostřednictvím podnikání, služeb a osobních příběhů.

Prezentace bude zcela zdarma.

Nejde nám o reklamu, ale o:

- vzájemné propojení a spolupráci v komunitě
- představení kvalitních mongolských výrobků a služeb české veřejnosti

Pokud chcete být součástí tohoto prostoru, ozvěte se nám.

Та бизнес эрхлэгч үү, эсвэл таны ажил Монгол Улстай ямар нэгэн байдлаар холбоотой юу?

Та үсчин, дасгалжуулагч, кашемир цамц худалдаалдаг, Монголын бараа бүтээгдэхүүн импортолдог, эсвэл Монгол хоолны ресторан ажиллуулдаг байх нь огт хамаагүй.

Бид бизнес, үйлчилгээ болон хувь хүний түүхээр дамжуулан Чех болон Монгол Улсыг холбож буй хүн бүрт зориулсан, ойлгомжтой бөгөөд найдвартай нээлттэй онлайн платформ бэлтгэж байна.

Энэхүү платформд танилцуулах нь бүрэн үнэ төлбөргүй.

Бид сурталчилгаа хийхийг зорьж буй биш, харин:

- хамтын нийгэмлэгийн хүрээнд харилцан холбоо тогтоох, хамтран ажиллах,
- Монголын чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг Чехийн олон нийтэд таниулахыг зорьж байна.

Хэрэв та энэхүү орон зайн нэг хэсэг болохыг хүсвэл бидэнтэй холбогдоорой.

Téma měsíce

HEPATITIDA D

Mongolsko patří dlouhodobě mezi oblasti s vysokým výskytem virové hepatitidy B (HBV) a D (HDV). Tato onemocnění často probíhají dlouho bez příznaků, ale neléčená mohou vážně poškodit játra.

Dobrou zprávou je, že včasné testování a léčba dokážou těmto následkům účinně předejít. V České republice je léčba hrazena ze zdravotního pojištění a je dostupná i pro Mongoly žijící v ČR.

- ✓ léčba neomezuje běžný život ani práci
- ✓ zaměstnavatel se o diagnóze nedozví
- ✓ zdravotní údaje jsou důvěrné a anonymní

Pečovat o své zdraví znamená chránit sebe i své blízké. Pokud máte možnost, využijte testování – včasné zjištění může zachránit zdraví i život.

D төрлийн гепатит

Монгол Улс нь В (HBV) болон D (HDV) вируст гепатитын тархалт өндөртэй орнуудын нэг юм. Эдгээр өвчин нь удаан хугацаанд ямар нэгэн шинж тэмдэггүй явагддаг ч эмчлээгүй тохиолдолд элгийг ноцтой гэмтээж болзошгүй.

Сайн мэдээ гэвэл эрт илрүүлж, эмчилгээг цаг тухайд нь эхлүүлснээр ноцтой хүндрэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Чех улсад гепатитын эмчилгээ нь эрүүл мэндийн даатгалаар бүрэн хариулагддаг бөгөөд Чех улсад амьдарч буй монгол иргэдэд ч хүртээмжтэй.

- Эмчилгээ нь өдөр тутмын амьдрал болон ажил хөдөлмөрт саад болохгүй
- Ажил олгогч таны оношийн талаар мэдэхгүй
- Эрүүл мэндийн мэдээлэл нь нууцлагдмал, бүрэн хамгаалагдсан
- Шинжилгээ, эмчилгээ нь аюулгүй, нууцлалтай байдлаар хийгдэнэ

Өөрийн эрүүл мэндэд анхаарах нь өөрийгөө болон ойр дотныхноо хамгаалж буй хариуцлагатай үйлдэл юм. Боломжтой бол шинжилгээнд хамрагдаарай – эрт илрүүлэлт нь эрүүл мэнд, амь насыг хамгаална.

Таны эрүүл мэнд , Таны ирээдүй!

ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДААРай.

Та өөрийгөө болон ойр дотныхоо хүмүүсээ хамгаалаарай.



Зарим өвчнүүд урт хугацаанд ямар ч шинж тэмдэггүй байж болох ч эрүүл мэндэд тань ноцтой хохирол учруулж болзошгүй.

ЦАГ АЛДАХГҮЙ ШИНЖИЛГЭЭ = ЦАГ АЛДАХГҮЙ ЭМЧИЛГЭЭ

ЭДГЭЭР ӨВЧНҮҮДИЙН ТУХАЙ МЭДЭХ ЧУХАЛ ЗҮЙЛС:

НIV ХАЛДВАР

- Цусаар, бэлгийн замаар, эхээс урагт дамждаг.
- Бүрэн эмчлэх боломжгүй боловч вирусг бие махбодид дарах эмчилгээ бий.
- Эрт илрүүлэлт-урт наслах, чанартайамьдралын боломж

С Т ТӨРЛИЙ ШАР ӨВЧИН

- Цусаар (жишээ нь ариун бус орчинд шивээс хийлгэх, мансууруулах бодис хэрэглэх, өмнө нь цус сэлбэх зэргээр) дамждаг.
- Удаан хугацаанд элгийг гэмтээж, хамгийн хүнд тохиолдолд элэгний хорт хавдар үүсгэж болзошгүй.
- Сайн мэдээ: Эмчилгээтэй бөгөөд энгийн, өвдөлтгүй!

В ТӨРЛИЙН ШАР ӨВЧИН

- Цус, бэлгийн замаар, эхээс урагт дамждаг.
- Элэг гэмтээж болзошгүй.
- Хроник хэлбэрийг эмчилж болно.
- Урьдчилан сэргийлэх вакцинтай!

D ТӨРЛИЙН ШАР ӨВЧИН

- Зөвхөн В төрлийн шар өвчний архаг хэлбэртэй хүмүүст тохиолддог.
- Удаан хугацаанд элгийг гэмтээж, хамгийн хүнд тохиолдолд элэгний хорт хавдар үүсгэж болзошгүй.
- Бүрэн эмчлэгдэх боломжгүй ч эмчилгээ бий.

ШИНЖИЛГЭЭ ХЭРХЭН ЯВАГДДАГ ВЭ?

- ✓ Түргэн бөгөөд ихэнх тохиолдолд өвдөлтгүй
 - ✓ Нээлттэй төвүүд ба шинжилгээний цэгүүд:
 - Нэрээ нууцалж болно, үнэ төлбөргүй
 - ✓ Мэргэшсэн төвүүд:
 - Эрүүл мэндийн даатгалаар үнэ төлбөргүй
- Иргэний дугаар эсвэл бусад үнэмлэх шаардлагатай

ХААНА ШИНЖИЛГЭЭ ӨГЧ БОЛОХ ВЭ?

Дэлгэрэнгүй мэдээлэл болон байршлуудыг:



WWW.TESTUJSEVCAS.CZ



С вирусын архаг гепатитийн эмчилгээний мэргэшсэн төвүүд

ЭРҮҮЛ МЭНД БОЛ ХАМГИЙН ҮНЭТ ЗҮЙЛ
Бүү хүлээ – өнөөдөр шинжилгээ өг.



Нáš web konečně v mongolštině

Web czechmongol.cz je nyní již dostupný také v mongolské jazykové mutaci. Díky tomu jsou informace o činnosti Společnosti česko-mongolského přátelství a spolupráce přístupnější širší části mongolské komunity v České republice.

S překladem nám velmi pomohla paní Narmandakh Boldbaatar, které tímto srdečně děkujeme.

Монгол хэл дээрх вэб сайт

Czechmongol.cz вэб сайт одоо монгол хэл дээрх хувилбартай боллоо. Ингэснээр Чех Улсад амьдарч буй монголчуудын өргөн хүрээнд Чех-Монголын найрамдал, хамтын ажиллагааны нийгэмлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл илүү хүртээмжтэй болж байна. Орчуулгын ажилд үнэтэй хувь нэмэр оруулсан Нармандах Болдбаатар танд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ZPRÁVY Z IOM A ICP PRAHA ИОМ БОЛОН ИСР-ИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Veškeré důležité zprávy, ať už informace od IOM ČR, či z Integrační centrum Praha, ale i z dalších oblastí, najdete přehledně na našem webu v sekci **Aktuality**.


Doporučujeme ji pravidelně sledovat, aby vám neunikly žádné důležité informace.

Zjistíte například, že projekt AVRR bude již brzy končit. Můžete si zkontrolovat, zda nejsou porušována Vaše pracovní práva atd.
<https://czechmongol.cz/aktuality/>

IOM Чех Улс, Прага хотын Интеграцийн төв болон бусад салбарын бүхий л чухал мэдээлэл, мэдээг та манай вебсайтын Мэдээ, мэдээлэл хэсгээс тодорхой, ойлгомжтой байдлаар авах боломжтой.

Чухал мэдээллийг алдалгүй авахын тулд уг хэсгийг тогтмол шалгаж байхыг зөвлөж байна.

Жишээлбэл, AVRR төсөл удахгүй дуусах гэж байгааг мэдэх боломжтой. Мөн таны хөдөлмөрийн эрх зөрчигдөж байгаа эсэхийг шалгах зэрэг хэрэгтэй мэдээллийг тэндээс олж болно.
<https://czechmongol.cz/mn/мэдээ/>



Соёл хоорондын эвлэрүүлэн зуучлалын Чех Монгол толь



Soninoos.nn

Vřele doporučujeme podcast/zpravodajský servis na youtube a instagramu SONINOOS.NN, který připravuje paní Narmandakh Boldbaatar. Pravidelně přináší přehledné informace o dění v České republice i v Evropě v mongolštině.



СОНИНООС

Бид YouTube болон Instagram дээрх “сониноос” подкаст / мэдээний сувгийг халуун дотноор санал болгож байна. Уг сувгийг Нармандах Болдбаатар бэлтгэдэг бөгөөд Чех Улс болон Европт өрнөж буй үйл явдлын талаарх ойлгомжтой мэдээллийг монгол хэлээр тогтмол хүргэдэг.

POZVÁNKY/МЭДЭГДЭЛ

Srděčně vás zveme na **workshop mongolské kaligrafie**, který se uskuteční 22. února v našich prostorách na Praze 8. Počet míst je omezený, proto je nutné se předem zaregistrovat a uhradit účastnický poplatek.

Už nyní se také můžete těšit na **březnovou přednášku pana dr. Šímy**, věnovanou českým stopám v Mongolsku a Číně, která nabídne řadu zajímavých historických i osobních souvislostí. Pro podrobnosti sledujte náš web a facebook.

Zároveň připravujeme druhé kolo **výstavy mladých mongolských umělců New Generation**, která bude ke zhlédnutí v našich prostorách přibližně od poloviny února do konce března. Těšit se můžete na obrazy, fotografie, tradiční i autorskou rukodělnou tvorbu a nově také na malé keramické sošky.

Та бүхнийг монгол бичгийн уран бичлэгийн семинарт урьж байна. Уг арга хэмжээ 2 дугаар сарын 22-нд Прага 8-д байрлах манай байранд зохион байгуулагдана. Суудлын тоо хязгаартай тул урьдчилан бүртгүүлж, оролцооны төлбөрийг төлөх шаардлагатай.

Мөн та бүхэн 3 дугаар сард болох ноён доктор Шимагийн “Монгол Улс болон Хятадад үлдсэн чех мөрүүд” сэдэвт лекцийг тэсэн ядан хүлээж болно. Энэхүү лекц нь түүхэн болон хувийн олон сонирхолтой баримт, холбоосыг хөндөнө. Дэлгэрэнгүй мэдээллийг манай вэб сайт болон Facebook хуудсаар дамжуулан аваарай.

Үүний зэрэгцээ бид Чех Улсад амьдарч буй залуу монгол уран бүтээлчдийн “New Generation” нэртэй үзэсгэлэнгийн хоёр дахь шатны бэлтгэлийг хийж байна. Үзэсгэлэн манай байранд ойролцоогоор 2 дугаар сарын дундаас 3 дугаар сарын эцэс хүртэл дэлгэгдэнэ. Та бүхнийг уран зураг, гэрэл зураг, уламжлалт болон орчин үеийн гар урлалын бүтээлүүд, мөн энэ удаад шинээр жижиг керамик баримлууд хүлээж байна.

MONGOLSKÁ KALIGRAFIE WORKSHOP



Fux Karachovič
www.fuxcaligraphy.com

Co se naučíte:

- ✓ **Základy mongolského písma a teorie kaligrafie**
Smysl tvarů, tradice a kontext
- ✓ **Základní tahy kaligrafie**
Práce se štětcem
- ✓ **Hluběji do kaligrafie**
Pokročilejší tahy, variace a osobní styl
- ✓ **Vlastní kaligrafické dílo plus bonus:-)**
Hotový výrobek, který si odnesete domů

- Všechny pomůcky obdržíte na workshopu.
- Malé občerstvení zajištěno.

Kdy a kde:

- 📅 22. února 2026
- 🕒 10.00 - 14.00
- 📍 **Svídnická 506/1A, Praha 8**
Budova Královské střední školy (vchod brankou vpravo)

CENA 1100,-
Rezervace předem nutná (počet míst omezen)

Rezervace:
<https://forms.gle/M5RAoTzvpJQZ2vcg8>
721 945 139
info@czechmongol.cz
www.czechmongol.cz



Společnost česko-mongolského přátelství a spolupráce

Chcete Newsletter a další zajímavosti dostávat pravidelně emailem do Vašich schránek?

Přihlašte se k odběru na našem webu:

<https://czechmongol.cz>

- Napište nám, co by se Vám v Newsletteru líbilo číst?
- Sdílejte jej se svými přáteli.
- Staňte se našimi spoluautory.

Манай мэдээллийн товхимол (newsletter) болон бусад сонирхолтой мэдээллийг тогтмол имэйлээр хүлээн авахыг хүсэж байна уу?

Манай вэб сайтаар дамжуулан захиалгад бүртгүүлээрэй:

<https://czechmongol.cz/mn/>

- Манай мэдээллийн товхимолд ямар сэдвийн талаар уншихыг хүсэж байгаагаа бидэнд бичээрэй.
- Найз нөхөдтэйгөө хуваалцаарай.
- Манай хамтран зохиогч болоорой.

Časopis PLAV - mongolské číslo - PLAV сэтгүүл – монгол дугаар

Na podzim loňského roku vyšlo mongolské číslo literárního časopisu Plav, které bylo slavnostně pokřtěno v našich prostorách. Akce měla velký úspěch a samotné číslo je dnes již zcela rozebrané, což nás velmi těší a potvrzuje mimořádný zájem o mongolskou literaturu.

Zájemci si však stále mohou zakoupit digitální verzi tohoto čísla na stránkách nakladatelství.
<https://www.svetovka.cz/2025/10/08-2025/>



Өнгөрсөн жилийн намар “Plav” утга зохиолын сэтгүүлийн монгол дугаар хэвлэгдэн гарч, манай байранд ёслол төгөлдөр танилцуулагдсан юм. Энэхүү арга хэмжээ маш амжилттай болж, уг дугаар хэвлэмэл байдлаараа бүрэн зарагдсан нь монгол утга зохиолд хандах онцгой их сонирхлыг илтгэж, бидний хувьд ихээхэн баярлуулсан үйл явдал байлаа.

Гэсэн хэдий ч сонирхсон уншигчид уг дугаарын дижитал хувилбарыг хэвлэлийн газрын вэб сайтаар дамжуулан худалдан авах боломжтой.

<https://www.svetovka.cz/2025/10/08-2025/>

Zdarma si můžete přečíst úvodník ve formě rozhovoru Veroniky Kapišovské s B. Mönchbajarem. Odkaz je zde:

<https://www.svetovka.cz/2025/10/2025-08-rozhovor1/>

Та Вероника Капишовскагийн Б. Мөнхбаяртай хийсэн ярилцлага хэлбэрийн удиртгал нийтлэлийг үнэ төлбөргүй унших боломжтой. Холбоос энд байна:

<https://www.svetovka.cz/2025/10/2025-08-rozhovor1/>

Výzva pro rodiče mongolských dětí - Монгол хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан уриалга

Máte mongolské dítě v české škole a potřebujete poradit se školním systémem, integrací nebo komunikací se školou? Ozvěte se nám. Připravujeme pravidelná setkání pro rodiče i děti, kde vám rádi pomůžeme a propojíme vás s dalšími rodinami.

Таны хүүхэд Чехийн сургуульд сурч байна уу? Чехийн боловсролын тогтолцоо, хүүхдийн тань дасан зохицол, сургуультай харилцах талаар зөвлөгөө хэрэгтэй бол бидэнтэй холбогдоорой. Бид эцэг эх, хүүхдүүдэд зориулсан тогтмол уулзалтуудыг бэлтгэж байна.

www.czechmongol.cz	info@czechmongol.cz
@mongol.space	facebook.com
www.mongol.space	Svídnická 506/1, Praha 8